



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**  
**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**АУДИТЫН ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ЗУРАГ ТӨСӨВГҮЙ, ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БАЙХАД БАТАЛДАГ ЗӨРЧИЛ ЖИЛ БҮР ДАВТАГДАЖ БАЙНА.**

**Аудитын сэдэв:** “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

**Аудитын код:** БХА-2026/05-03/ШТА-НА

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

---

**Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

**Аудитын менежер М.Алтантуяа**

Утас: 70442424 цахим хуудас: [altantuyam@audit.gov.mn](mailto:altantuyam@audit.gov.mn)

**Ахлах аудитор Б.Должмаа**

Цахим хуудас: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

**Аудитор Д.Цэдэвцэвээн**

Цахим хуудас: [tsedevtseveend@audit.gov.mn](mailto:tsedevtseveend@audit.gov.mn)

**Аудитор Д.Даваадорж**

Цахим хуудас: [davaadorjd@audit.gov.mn](mailto:davaadorjd@audit.gov.mn)

Баянхонгор хот.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 4/12

Номгон

Г Гүйцэтгэлийн аудитын тайлан Г  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/175 дугаар тушаалаар баталсан “Эрх шилжүүлэх” тухай тушаалын 3 дугаар хавсралтын 1 дэх заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” (ГНАГ-2026/03-ШТА-НА кодтой) сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Н.Батсуурь, аймгийн Засаг дарга Э.Энхбат, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэг, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, аймгийн Худалдан авах ажиллагааны газар, Баянхонгор сумын Засаг дарга М.Насанбат нарт хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Должмаа)-д даалгасугай.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2027 оны 01 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Баянхонгор аймгийн Засаг дарга (Э.Энхбат), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа) нарт зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Б.Должмаа), аудитор (Д.Цэдэвцэвээн) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Алтантуяа)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР  Б.МӨНХБАТ

<u>Тайланг хянасан</u>	
Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат	ХҮСНЭГТ, ТОВЧИЛСОН ҮГИЙН МЭДЭЭЛЭЛ .....6
Аудитын менежер М.Алтантуяа	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....7-8
Тайланг бэлтгэсэн:	<b>ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ..... 9</b>
Ахлах аудитор Б.Должмаа	<b>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛИЙН ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ БАЙНА..... 11</b>
Аудитор Д.Цэдэвцэвээн	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна..... 11-12
Аудитор Д.Даваадорж	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө нэгдсэн судалгаа бэлтгэж, эрэмбэлээгүй, зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээг оруулсан байна..... 13
2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр	<b>БҮЛЭГ 2. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ, ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА..... 15</b>
Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Зураг төсөв, техникийн тодорхойлолт бүрэн боловсруулагдаагүй байхад төлөвлөлт хийсэн нь худалдан авах ажиллагаа хугацаандаа зохион байгуулагдахгүй саатах, удаашрах эрсдэлийг бий болгож байна..... 15
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.	Тайлант хугацаанд тендер сонгон шалгаруулалттай холбоотой гомдол ирээгүй, цахим системийн бүртгэл мэдээлэлд Төрийн худалдан авах ажиллагааны газраас хяналт шинжилгээ хийгдээгүй байна..... 19
ХАЯГ:	<b>БҮЛЭГ 3. ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА. 19</b>
<i>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Нутгийн удирдлагын ордон, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум 64090, Баянхонгор аймаг Монгол Улс</i>	Тайлант орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна..... 19
	Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОНХОБТ нь өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, албан шаардлагын хариуг заасан хугацаанд ирүүлээгүй байна. .... 23
	<b>ДҮГНЭЛТ .....26</b>
	<b>ЗӨВЛӨМЖ .....27</b>
	<b>ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ..... 28-30</b>

## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОНХОБТХ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ХА	Харьцуулалтын арга
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл

## Хүснэгтийн жагсаалт

№	Агуулга	Хуудасны дугаар
1	Аудитад хамруулсан төсөл, арга хэмжээний мэдээлэл	6
2	Бодлогын баримт бичгийн ангилал, төсөл арга хэмжээний тоо, баталсан дүнгээр (сая.төг)	7
3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ (сая.төг)	8
4	Хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа холбоо	8-9
5	Худалдан авах ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 31-ны өдрөөс хойш зохион байгуулсан төсөл арга хэмжээ	14
6	Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт	20

## Дүрслэлийн жагсаалт

№	Агуулга	Хуудасны дугаар
1	Хөгжлийн бодлоготой уялдсан байдал	9
2	Салбарын ангилал (төсөл арга хэмжээний тоо, мөнгөн дүн)	11
3	Нээлттэй тендер (НТШ) болон харьцуулалтын арга (ХА)-аар зохион байгуулсан худалдан авах ажиллагааны дундаж зарцуулсан хугацаа	13

## Хавсралт судалгааны жагсаалт

№	Агуулга	Хуудасны тоо
1	Төсөл, арга хэмжээг хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх судалгаа	2
2	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны судалгаа	3
3	Төсөл, арга хэмжээний санхүүжилт бүртгэлийн судалгаа	4
4	Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийн судалгаа	2
5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн судалгаа	2

## **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны аудитын сэдэв батлах тухай 2025 оны 25 дугаар тогтоол, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/01 тоот тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

## **Аудитын зорилго**

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ-ын ГАГ, Нийслэл дэх Төрийн аудитын газар болон аймгийн ИТХ, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

## **Аудитын хамарсан хүрээ**

Орон нутгийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд болон аймгийн ГХБХБГ, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, сумдын ЗДТГ, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

## **Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал-ын дагуу аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, ярилцлага, судалгаа хийх зэрэг аудитын арга зүйг ашиглав.

## **Аудитын шалгуур үзүүлэлт**

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Авто замын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам.
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм
- Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам
- Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм
- Барилгын ажлын захиалагчийн дүрэм
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд
- Батлагдсан зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ, бусад холбогдох эрх зүйн актууд.

### **Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлэн, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Д.Цэдэвцэвээн, Д.Даваадорж нар аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хөндлөнгийн мэргэжлийн шинжээч авч ажиллуулаагүй болно.

### **Аудитыг гүйцэтгэхэд учирсан хүндрэл, бэрхшээл**

Байхгүй

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/28 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийн 2025 оны төсвийг баталжээ.

*Хүснэгт 1. Аудитад хамруулсан төсөл, арга хэмжээний мэдээлэл*

Эх үүсвэр	ТАХ тоо	Шилжих	Шинэ	Сумдад эрх шилжүүлсэн ТАХ-ний тоо
Замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх	15	0	15	6
Орон нутгийн төсвөөс 2025 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар	26	19	7	2
Баянхонгор аймгийн 2025 оны хөгжүүлэх төлөвлөгөө	2	0	2	
Нийт	43	19	24	8

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн 2025 оны төсөв баталсан тогтоолууд*

Орон нутгийн төсвөөс 2025 онд хийгдэх төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засварын жагсаалтыг батлахдаа өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа 1,430.9 сая төгрөгийн өртөг бүхий 19 төсөл арга хэмжээнд 735.8 сая, тайлант онд шинээр эхлэх 6,936.7 сая төгрөгийн өртөг бүхий 3,447.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Замын сангийн хөрөнгөөр 2025 онд 2,978.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2,035.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 15 төсөл арга хэмжээг тайлант онд төлөвлөж баталсан байна. Үүнээс 14 төсөл арга хэмжээг тайлант онд бүрэн санхүүжүүлж, харин 1,848.9 сая төгрөгийн өртөг бүхий Баянхонгор сумын 3 дугаар сургуулийн баруун урд уулзвараас Нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэл 1.3 км авто зам тавих ажилд 2025 онд 906.2 сая төгрөгийг санхүүжүүлж, үлдэгдэл санхүүжилтийг дараа онд олгохоор төлөвлөжээ.

Баянхонгор аймагт 2025 онд аймгийн хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаар санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтаар шинээр 2,248.9 сая төгрөгийн 50 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас хөрөнгө оруулалтын шинжтэй 300.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ байна.

Тайлант онд 4,539.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг явуулснаас нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан 8 төсөл, арга хэмжээнд дунджаар 49 хоног, харьцуулалтын аргаар зохион байгуулсан 5 төсөл, арга хэмжээнд дунджаар 20 хоног зарцуулсан бөгөөд 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс хойш зохион байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 43 төсөл, арга хэмжээг ангиллаар нь авч үзэхэд 23 төсөл, арга хэмжээ буюу 43.4 хувийг орон нутгийн хөгжил, дэд бүтцийн салбарт зарцуулсан байна.

Хүснэгт 2. Бодлогын баримт бичгийн ангилал, төсөл арга хэмжээний тоо, баталсан дүнгээр (сая.төг)

№	Бодлогын баримт бичгийн ангилал	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөл, арга хэмжээний	
			Тоо	Баталсан дүн
1	Орон нутгийн хөгжил, дэд бүтэц	Авто зам, дэд бүтэц	15	2,035.58
		Их засвар, тохижилт	8	514.8
2	Биеийн тамир, спорт	Их засвар, тохижилт	3	498.4
3	Боловсролын салбар	Их засвар, тохижилт	12	1,991.6
4	Соёл	Их засвар, тохижилт	1	263.4
5	Эрүүл мэнд	Их засвар, тохижилт	2	178.8
6	Техник хэрэгсэл	Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх	2	300.0
<b>ДҮН</b>			<b>43</b>	<b>5,782.5</b>

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоолууд

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5,782.5 сая төгрөгийн 43 төсөл арга хэмжээнээс тайланд онд 37 төсөл арга хэмжээнд 5,141.5 сая төгрөгийг олгож, гүйцэтгэгч 5 аж ахуйн нэгжүүдээс 561.9 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэн санхүүжилт авах хүсэлтийг (гүйцэтгэлийг) ирүүлсэн байхад орон нутгийн төсвийн орлого тасарснаас шалтгаалж санхүүжилтийг олгоогүй, Баян-өндөр сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажилд баталсан 28.9 сая төгрөгийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс ажлын гүйцэтгэл гаргаж ирээгүйн улмаас олгоогүй байна.

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

### БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛИЙН ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ БАЙНА.

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.**

1.1. Баянхонгор аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/28 дугаар тогтоолоор анх орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд 6,729.7 сая төгрөгийн санхүүжилтээр 47 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Дээрх тогтоолд 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 8/45 дугаар тогтоолоор төсөвт өөрчлөлт оруулж, 5,782.5 сая төгрөгийн 43 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 19 нь өмнөх оноос шилжин хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ бөгөөд шинээр 24 төсөл, арга хэмжээг баталжээ.

*Хүснэгт 3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ (сая.төг)*

Тогтоолын дугаар	Үзүүлэлт	Замын сан	Их засварын ажил	Хөгжлийн төлөвлөгөө	Нийт
Аймгийн ИТХ-ын 2024.12.20-ны өдрийн 4/28	ТАХ тоо	16	29	2	47
	Мөнгөн дүн	2,317.0	4,112.7	300.0	6,729.7
Аймгийн ИТХ-ын 2025.08.26-ны өдрийн 8/45	ТАХ тоо	15	26	2.0	43
	Мөнгөн дүн	2,035.5	3,447.0	300.0	5,782.5
<b>ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ДҮН</b>		<b>-281.5</b>	<b>-665.7</b>	<b>0</b>	<b>-947.2</b>

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоолууд*

1.2. 2025 оны орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 43 төсөл, арга хэмжээ нь Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

*Хүснэгт 4. Хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдаа холбоо*

Салбар	Төсөл, арга хэмжээ	Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Баянхонгор аймгийн хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
1 Дэд бүтэц	Баянхонгор сумын 3-р сургуулийн 1.3 км авто зам, Баянхонгор сумын Цагаан чулуут, Гэгээн шавь багт 1.5 км явган хүний зам тавих, 1 дүгээр багийн зам талбайн засвар, замын нөхөөс хийх, шаардлагатай газруудад хучилт хийх Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац, Ахмадын хороо, Бууцагаан сум дахь Гал түймэр унтраах аврах 72 дугаар ангийн ажлын байр, аймгийн ИТХ-ын конторын засварын ажил, Мазаалай паркийн усалгааны төв шугамын шинэчлэлт, засварын ажил, Бууцагаан сумын Наран, Баянбүрд багийн зам давааны засвар, Нэгдсэн эмнэлгийн гадна зогсоолын засвар, Баянхонгор сумын явган хүний гарц, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх, Бууцагаан сумын зам дагуух талбайн тохижилт гэрэлтүүлэг, Эрдэнэцогт суманд ковш авах, Богд сумын гүүрний зам засвар, Өлзийт суманд шилэн кабел холбох, Аймгийн шинэ	Барилга байгууламжийг шинэчлэх, ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. (2.1.7.2), Аймгийн авто замын тэмдэг тэмдэглэгээ, гэрлэн дохиог стандартад нийцүүлэн аюулгүй байдлыг хангана. (2.2.3.7)	Сум, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. (8.1), Барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах. (8.1.9), Барилгын чанар, дулаан хамгааллыг сайжруулна. (6.2.3.1), Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулна. (4.4.4.1), Улсын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээнд эзлэх

	суурьшлын бүсийн 10 км авто замын зураг төсвийн үнэ		хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлнэ. <b>(5.6.1.1)</b>
2	Боловсролын салбар	Галуут, Богд, Хүрээмарал, Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн барилга, Бууцагаан, Баянбулаг сумын сургууль, Жаргалант, Өлзийт, Баацагаан сумын сургуулийн дотуур байр, Баянцагаан, Гурванбулаг, Баянхонгор сумын Шаргалжуут 8 дугаар багийн спорт заалны засварын ажил	Барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. <b>(2.1.7.2)</b> , Хүүхдийн эрүүл аюулгүй орчны стандартын хангалтыг нэмэгдүүлнэ. <b>(2.1.2)</b>
3	Биеийн тамир, спорт	Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын халаалтын шугамын засварын ажил, Бөмбөгөр сумын спорт заал, Өвгөн жаргалант зуслангийн спортын талбайн тохижилт, засварын ажил	Барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. <b>(2.1.7.2)</b> , Хүүхдийн эрүүл аюулгүй орчны стандартын хангалтыг нэмэгдүүлнэ. <b>(2.1.2)</b>
4	Эрүүл мэнд	Баян-Өндөр, Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажил	Барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. <b>(2.1.7.2)</b> , Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. <b>(2.2.1.5)</b>
5	Соёл	Хүүхдийн Тэмүүжин театрын их засварын ажил	Барилга байгууламжийг барих, шинэчлэх, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. <b>(2.1.7.2)</b> , Хүүхдийн эрүүл аюулгүй орчны стандартын хангалтыг нэмэгдүүлнэ. <b>(2.1.2)</b>
6	Техник хэрэгсэл	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин	Төрийн албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлнэ. <b>(4.1.4)</b>
			Барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах. <b>(8.1.9)</b> , Нийтийн биеийн тамир хөгжүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх <b>(3.3.3)</b> , Биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна. <b>(1.2.2.1)</b>
			Барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах. <b>(8.1.9)</b> , Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлнэ. <b>(1.2.1.1)</b>
			Барилга байгууламжийн нөхцөлийг сайжруулах. <b>(8.1.9)</b>
			Төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, төрийн албаны нэр хүндийг өсгөнө. <b>(7.3.1.2)</b>

Эх сурвалж: Хөгжлийн бодлогын баримт бичгүүд



Дүрслэл 1. Хөгжлийн бодлоготой уялдсан байдал

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө нэгдсэн судалгаа бэлтгэж, эрэмбэлээгүй, зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээг оруулсан байна.**

1.4. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн мэргэжилтнүүдийн тогтворгүй байдал, төлөвлөлтийн болон хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүдийн ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалж орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлттэй нотлох баримт хангалтгүй, төсөл, арга хэмжээний нэр, төсөвт өртгийг алдаатай гаргасан байна. Аймгийн ИТХ-аар төсвийн төслийг хэлэлцүүлэх явцад төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэлэлцэн баталсан байа.

#### **Аудитын илрүүлэлт:**

1. Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 23 төсөл, арга хэмжээний зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй, магадлалаар баталгаажаагүй, төсөвлөлтийн үндэслэл, шаардлагыг хангаагүй, техникийн тодорхойлолтыг боловсруулаагүй;
2. Аймгийн ИТХ-ын 2024 оны төсөв батлах тухай 4/28 дугаар тогтоолоор “Баянхонгор сумын 314, 316 дугаар байрны дээврийн засварын ажилд” 5.0 сая төгрөгийг баталсан байхад 316 дугаар байранд засвар хийгээгүй байна. Энэ нь төсөвлөлтийг үндэслэлгүй хийснээс санхүүжилт хүрээгүйгээс шалтгаалжээ;
3. Аймгийн ИТХ-ын 2024 оны төсөв батлах тухай 4/28 дугаар тогтоолоор Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэлх 1.3 км авто зам тавих ажлын зураг 1.0 км замаар зурагтай хэдий ч 1.5 км замын төсөвтэй, гэрээг 1.3 км авто замаар хийсэн нь цаашид төсвийн маргаан үүсэх эрсдэлтэй;
4. Гурванбулаг сумын сургуулийн дотуур байрны 710,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засварын ажлын гүйцэтгэгч 2024 онд шалгарч 677.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байхад 2025 оны ИТХ-ын тогтоолоор анх баталсан 710,0 сая төсөвт өртгийг 33.0 сая төгрөгөөр хассан;
5. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний цаашид гарах урсгал зардлыг тооцоогүй;
6. Замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зураг, төсвийг бодитой төлөвлөөгүйгээс 570.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн дүнд өөрчлөлт оруулан 489.6 сая төгрөг болгож, 80.4 сая төгрөгөөр бууруулж баталж байгаа нь анх төлөвлөсөн тоо хэмжээндээ хүрэхгүйгээс ажил чанаргүй, дутуу хийгдэж, баталсан төсөвт багтаан ажлыг гүйцэтгэхэд хүргэж байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>1</sup>, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2.1<sup>2</sup>, 2.2.2<sup>3</sup>, 2.2.4<sup>4</sup> дэх заалтуудыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

<sup>2</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: Төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэн, эрэмбэлэх, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тогтоох;

<sup>3</sup> Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;


<sup>4</sup> Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх

**Шийдвэрлэлт:** Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө олон нийтээр хэлэлцүүлсэн байх, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, үнийн судалгаа, тооцоололд үндэслэн ТЭЗҮ, шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж, ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өгч, аймгийн ИТХ-д толилуулав.

1.5 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5<sup>5</sup> дахь заалтын дагуу тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 24 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан хуваарилж төлөвлөсөн байна.

1.6 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг салбараар нь авч үзвэл дийлэнх төсөл, арга хэмжээг дэд бүтцэд зарцуулахаар төлөвлөжээ.

Дүрслэл 2. Салбарын ангилал (төсөл арга хэмжээний тоо, мөнгөн дүн-сая.төг)



1.7. Баянхонгор аймгийн ИТХ-ын 2025 оны 8/45 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тодорхойлохдоо замын санг ерөнхий байдлаар тодорхойлж, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний хүрэх үр дүнгийн тоо болон чанарын үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.

#### Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тайлагнахдаа замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дуусаагүй ажлыг дууссанаар тайлагнасан, тайлант онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ тус бүрээр хүрсэн үр дүнг тайлагнаагүй байна.

<sup>5</sup> шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйцээр тодорхой болгох зөвлөмжийг Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгсөн тул цаашид орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний хүрэх үр дүнгийн тоо болон чанарын үзүүлэлтийг үнэн зөв төлөвлөх, тайлагнахад БОНХОБТХ-ээс анхаарч ажиллахыг зөвлөв.

1.7. Замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Баянхонгор сумын 3 дугаар сургуулийн баруун урд уулзвараас нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэлх 1.3 км авто зам тавих ажлын гүйцэтгэгчтэй 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 1,848.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 55.9 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулжээ.

Гүйцэтгэгчтэй байгуулсан дээрх гэрээнүүдийн нийт дүнгээр 1,904.8 сая төгрөгийг олгохоор байхад 2025 оны төсөвт 906.2 сая төгрөгийг баталж олгосон, 2026 оны төсөвт 1,002.8 сая төгрөгийг баталсан нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дүнгээс 4.2 сая төгрөгөөр илүү байна. Иймд 2026 онд аймгийн ИТХ-ын тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулахыг аймгийн ИТХ-д толилуулав.

## **БҮЛЭГ 2. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ, ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА**

---

**Зураг төсөв, техникийн тодорхойлолт бүрэн боловсруулагдаагүй байхад төлөвлөлт хийсэн нь худалдан авах ажиллагаа хугацаандаа зохион байгуулагдахгүй саатах, удаашрах эрсдэлийг бий болгож байна.**

2.1. Баянхонгор аймгийн замын сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх төсөл арга хэмжээний төсвийг аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/28 дугаар тогтоолоор баталсны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн төсөв, бусад сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний 2025 оны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/738 дугаар захирамжаар хуульд заасан хугацаанд баталсан байна.

2.2. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулах 15 төсөл арга хэмжээнээс тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/06 тоот захирамж, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/30 тоот захирамжаар Баянхонгор сум, Эрдэнэцогт сумдын ЗДТГ-т 2,987.0 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг эрх шилжүүлсэн ба худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулах боломжоор хангасан байна.

2.3. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим төсөл арга хэмжээг хуульд заасны дагуу багцад хуваахдаа Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтад заасан "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар"-аас бага үнээр хуваан шууд гэрээ байгуулсан байна. Тухайлбал:

- Баянхонгор сумын Засаг даргад эрх шилжүүлсэн 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Нэгдсэн эмнэлгийн гадна зогсоолын засвар" ажлыг 12 багцад;
- Баянхонгор сумын Засаг даргад эрх шилжүүлсэн 165.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Баянхонгор сумын А зэрэглэлийн бүсийн тоосжилтыг бууруулах зорилгоор шаардлагатай газруудад хучилт хийх" ажлыг 9 багцад хуваан шууд гэрээ байгуулсан байна.

Дээрх тендер зарлалгүй багцад хуваан шууд гэрээ байгуулсан зөрчилд Баянхонгор сумын ЗДТГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар аймгийн замын сангаар хэрэгжих төсөл арга хэмжээг эрх шилжүүлэн хэрэгжүүлдэг байдлыг таслан зогсоох, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх албан шаардлага өгсөн.

2.4. Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 1/10 дугаар албан бичгээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг холбогдох захиалагч байгууллагуудаас ирүүлэхийг мэдэгдсэн боловч худалдан авах ажиллагааны хугацаатай давхцуулж оройтуулж ирсэн гэсэн тайлбарыг тус газраас өгсөн болно.

2.5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжүүлэхээр баталсан нийт 43 төсөл, арга хэмжээнээс 23 төсөл, арга хэмжээнд шинээр гэрээ байгуулан ажилласан бөгөөд эдгээрээс худалдан авах ажиллагаа зохион байгуулж тендер зарлах 15 төсөл, арга хэмжээний 2-т шууд гэрээ байгуулан 13 төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг тус бүр үнэлгээний хороо байгуулсны дараа аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн байна.

2.6. Аудитаар 4,539.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичиг, тендерийн өгөгдлийн хүснэгтийг шалгахад тухайн төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээтэй уялдуулан оролцогчийн санхүүгийн чадавх, туршлага, техникийн боломж, хүний нөөцтэй холбоотой шаардлагыг тусган боловсруулж тендер шалгаруулалтыг зарласан байна.

2.7. Тайлант хугацаанд зохион байгуулсан 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд нийт 498 хоног зарцуулсан бөгөөд нэг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд дунджаар 38.3 хоног зарцуулсан байна.

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан 8 төсөл, арга хэмжээнд дунджаар 49.8 хоног, харьцуулалтын аргаар зохион байгуулсан 5 төсөл, арга хэмжээнд дунджаар 20 хоног зарцуулсан байна.

Дүрслэл 3. Нээлттэй тендер (НТШ) болон харьцуулалтын арга (ХА)-аар зохион байгуулсан худалдан авах ажиллагааны дундаж зарцуулсан хугацаа.



#### Аудитын илрүүлэлт:

- Орон нутгийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр баталсан 1,151.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлахдаа 05 дугаар сарын 31-ний өдрөөс хойш зарласан, тус төсөл арга хэмжээний санхүүжилтийг хэмнэлтэд тооцон татан төвлөрүүлээгүй;
- Тус зөрчил өмнөх аудитаар илэрч, аймгийн Засаг даргад зөвлөмж өгсөн байхад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1<sup>6</sup>, 13.1.2<sup>7</sup> дахь заалт, Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Төсвийн хэмнэлтэд тооцох тухай” 02 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт:** Цаашид зөрчлийг таслан зогсоож 2026.05.31-нөөс хойш Засгийн газрын тогтоол болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг хугацаанд багтаан тендер зарлаж байх албан шаардлагыг аймгийн ХААГ-ын даргад, төсвийн хэмнэлтийг хуульд заасан хугацаанд төсөвт төвлөрүүлэх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТХС-т өгөхөөр шийдвэрлэв.

2.8. Худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй шалтгаан нь төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн бэлэн байдал хангагдаагүйгээс худалдан авах ажиллагаа удааширсантай холбоотой байна.

<sup>6</sup> 13.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална: 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

<sup>7</sup> 13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;

Хүснэгт 5. Худалдан авах ажиллагааг 2025 оны 05 дугаар сарын 31-ны өдрөөс хойш зохион байгуулсан төсөл арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нар	Төсөвт өртөг (сая.төг)	Тендер зарласан огноо	Тендерийг амжилттай зохион байгуулсан эсэх	Тендер шалгаруулалт зохион байгуулсан удаа
1	Аймгийн Засаг Даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин	60.0	2025.09.10	Тийм	1
2	Хүүхдийн тэмүжин театрын их засварын ажил	521.2	2025.05.20 2025.06.17	Тийм	2
3	Баянхонгор сумын Цагаан чулуут, Гэгээн шавь багт 1.3 км явган хүний зам тавих	220.0	2025.06.05	Тийм	1
4	Баянхонгор сумын дотор эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх (Замын сангийн хөрөнгөөс 100.0 сая төгрөг сумын 2026 оны ОНХС-ын хөрөнгөөс 50.0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлхээр баталсан)	150.0	2025.07.22 2025.07.29	Тийм	2
5	Баянхонгор сумын явган хүний гарц, хэвтээ тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлэх	200.0	2025.06.18	Тийм	1
ДҮН		1,151.2			

Эх сурвалж: tender.gov.mn

Төсөл, арга хэмжээ нь техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн бэлэн байдал хангагдаагүй, холбогдох техникийн баримт бичиг дутуу байснаас тендерийн хүлээн авах хугацааг удаашрах нөхцөл үүссэн байна.

Төсөв батлах эрх бүхий байгууллага төсөв батлахдаа Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 <sup>8</sup> дэх заалтын дагуу төсөл, арга хэмжээний зураг төсөв, техникийн тодорхойлолтын бэлэн байдлыг харгалзан үзэж, холбогдох баримт бичиггүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх нь худалдан авах ажиллагаа хуульд заасан хугацаанд зохион байгуулагдах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна төсөвт өртгийг хэт өндөр эсхүл хэт бага батлах эрсдэлийг бууруулах ач холбогдолтой байна.

Төрийн аудитын байгууллагаас өмнөх оны аудитаар аймгийн ИТХ-д Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн барьсан төсөвт өөрчлөлт оруулан батлахдаа ТЭЗҮ хийгээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталснаас хөрөнгө оруулалтын төлөвлөгөө тасарч төсвийн хөрөнгийн үр ашиг гарахгүй байгаа асуудлыг толилуулсан боловч тус зөрчил аудитаар давтагдаж байгаа тул аймгийн ИТХ-д тус асуудлыг дахин толилуулж байна.

2.9. Тайлант онд зохион байгуулсан 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанаас дараах төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичигт

<sup>8</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

заасан шаардлагыг бүрэн хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна. Тухайлбал:

#### **Аудитын илрүүлэлт:**

• *Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан Эрдэнэцогт сумд эрх шилжсэн 170,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Сумын төвийн хогийн зам даваа засах тусгай зориулалтын техниктэй болох /Ковш/" ажилд тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуурыг хангаагүй аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулсан байна.*

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7<sup>9</sup> дугаар зүйл, 15<sup>10</sup> дугаар зүйл, 16<sup>11</sup> дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт:** Цаашид тендерт шаардлага хангаагүй оролцогчийг сонгон шалгаруулахгүй байх, алдаа, зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг Эрдэнэцогт сумын Засаг даргад өгөхөөр шийдвэрлэв.

**Тайлант хугацаанд тендер сонгон шалгаруулалттай холбоотой гомдол ирээгүй, цахим системийн бүртгэл мэдээлэлд Төрийн худалдан авах ажиллагааны газраас хяналт шинжилгээ хийгдээгүй байна.**

2.10. Тайлант хугацаанд замын сан болон орон нутгийн төсвөөс хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой сонгон шалгаруулалтын гомдол Сангийн яаманд гаргаагүй байна.

2.11. Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь цахим системийн бүртгэл, мэдээлэлд хяналт тавих эрхгүй бөгөөд Баянхонгор аймгийн хэмжээнд 2025 онд Төрийн худалдан авах ажиллагааны газраас цахим системийн бүртгэл, мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

2.12. Харин аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2025 онд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд захиалагч байгууллагуудын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар тогтмол хангаж ажилласан байна.

### **БҮЛЭГ 3. ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.**

**Тайлант орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр төлөвлөсөн үр дүнд хүрсэн байна.**

<sup>9</sup> Оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах;

<sup>10</sup> Чадаахын болон туршлагын шаардлага тавих үндэслэл;

<sup>11</sup> Санхүүгийн чадаахын шаардлага;

3.1. Баянхонгор аймгийн Замын сангийн хөрөнгөөр тайлант онд 2,035.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.1<sup>12</sup>-т заасны дагуу төлөвлөж, замын сангийн эхний үлдэгдлээс 630.0 сая, орон нутгийн төсвөөс 1,405.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-аар баталжээ.

3.2. Замын сангийн харилцах дансны эхний үлдэгдэл 637.6 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд орон нутгийн төсвийн орлого 529.4 сая төгрөгөөр давж биелэн, төлөвлөсөн 15 төсөл, арга хэмжээний зардалд 2,031.7 сая төгрөгийг олгож, оны эцэст замын сангийн харилцах данс 540.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

3.2. Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 28 төсөл арга хэмжээний 3,747.0 сая төгрөгийн санхүүжилтээс Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн засварт гүйцэтгэл гараагүйгээс 28.8 сая төгрөгийн санхүүжилт хэрэгжээгүй бөгөөд бусад 22 төсөл, арга хэмжээний зардалд 3,109.8 сая төгрөгийг олгосон байна.

3.3. Тайлант хугацаанд хэрэгжүүлж, гүйцэтгэгчээс санхүүжилтийн гүйцэтгэл ирүүлсэн 5 төсөл, арга хэмжээний зардалд 561.9 сая төгрөгийг олгоогүй нь орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотой байна.

3.4. Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдээс 561.9 сая төгрөгийг гүйцэтгэлийн санхүүжилтийг 2025 оны 8-10 дугаар сард ирүүлсэн ч санхүүжилтийг олгоогүй нь гүйцэтгэгч гэрээний үүргийн дагуу ажлыг хугацаанд нь хүлээлгэн өгөх, ажил удаашрах, чанаргүй хийх сөрөг нөлөөтэй тул цаашид санхүүжилтийг тухай бүрд олгох арга хэмжээг орон нутгаас авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

### **Аудитын илрүүлэлт**

- *Баян-өндөр сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажлын захиалагч, гүйцэтгэгчийн хооронд 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 2024/11 дугаартай гэрээ байгуулж, 168.8 сая төгрөгөөр тус ажлыг гүйцэтгэж, 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ашиглалтад оруулж, их засварын зардлаас 2024 онд 140.0 сая, 2025 онд 28.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр заажээ. Тус ажлыг гүйцэтгэгчээс тайлант онд гүйцэтгэлийн санхүүжилт гаргаж ирүүлээгүйгээс санхүүжилт олгоогүй байгаа бөгөөд тус ажлыг одоо болтол хүлээн аваагүй, захиалагчаас гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнээгүй, гэрээний 7.1-т заасан гэрээг цуцлах арга хэмжээ авч ажиллаагүй байна.*

Энэ нь Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн хооронд байгуулсан "Баян-Өндөр сумын Эрүүл мэндийн төсвийн засварын ажлын захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулсан 2024/111 дугаар гэрээ"-ний 3.1<sup>13</sup>, гэрээний тусгай нөхцөлийн ГЕН 10.22<sup>14</sup> гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Шийдвэрлэлт:** Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг дүгнэж, гэрээнд заасан хариуцлагын зохицуулалтыг мөрдөж, шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад

<sup>12</sup> Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих үйл ажиллагааг улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, дотоод, гадаадын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ

<sup>13</sup> Гүйцэтгэгч улсын техникийн тодорхойлолт, зураг төсөөт тусгагдсаны дагуу 2024.09.23-ны өдрөөс эхлэн, 2024.12.25-ны өдөр ажлыг 100 хувь гүйцэтгэж ашиглалтад оруулна

<sup>14</sup> Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: хоног тутамд 0.5 хүртэлх хувиар тогтооно" 7.1 "Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно"

шилжүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ын дарга нарт өгөхөөр шийдвэрлэв.

3.5. Баянхонгор аймгийн ГХБХБГ-аас орон нутгийн төсвөөс хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн техникийн хяналтыг тухай бүрд бүрэн хэрэгжүүлсэн ч аудитаар дараах ажлуудыг чанаргүй, дутуу хийсэн зөрчил илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт**

- Галуут сумын цэцэрлэгийн их засварын ажлын чанар байдлыг аудитаар тулган шалгахад шилэн хаалганы ханын доторлогоо, өнгөлгөө бүрэн хийгдээгүй, дээд, доод булангуудын дулаалга дутуу хийгдсэнээс өвөл хүйтэн, дулааны улиралд шороо их ордог, шалны доороос цемент гарсан, нэг давхрын анги танхимын хана, таазны залгаа зарим газар салсан;
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2025.08.04-ний өдрийн 2025/09 дугаартай дүгнэлтээр Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны засварын ажлыг хүлээн авсан ба комиссын гишүүдээс өгсөн холбоо, дохиоллын ажлыг хийж хүлээлгэн өгөөгүй байна. Аудитаар хийсэн ажлыг тулгахад ханын тэгшилгээ, будаг, шалны тэгшилгээ суулт өгч зарим газар хагарсан, гадна талын гэрэлтүүлэг ажиллаагүй, хаалганы бариулыг суулгаж өгөөгүй;
- Хүрээмарал сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлыг тулган шалгахад паркетан шалны ам даралт бүрэн хийгдээгүй, зарим ангийн шал хөндийрсөн, ховхорсон, ханын будгийн тэгшилгээ зарим газар муу хийгдсэн;
- Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг тулган шалгахад агуулахын өрөөний дээврийн хэсгээс ус гоожсон, дээврийн ус зайлуулах хоолой барилгын баруун талд салж, барилгын гадна хана руу ус гоожсон байна.

Энэ нь Барилын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6<sup>15</sup>, 37 дугаар зүйлийн 37.1.4 “барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах”, 42 дугаар зүйлийн 42.1.6 “барилгын ажлын үе шатанд хяналт тавих, барилга байгууламжийн ашиглалтын үеийн чанар, аюулгүй байдлын төлөвт дүгнэлт гаргах”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4.2<sup>16</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт:** Дутуу болон чанаргүй хийсэн ажлуудыг бүрэн хийлгүүлж, захиалагчийн хяналтыг тавьж хүлээн авах албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т өгөхөөр шийдвэрлэв.

3.6. Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 2,035.4 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээнээс 768.6 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 7 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

<sup>15</sup> Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

<sup>16</sup> Төсөл, арга хэмжээг хуулиар баталсан хугацаанд бүрэн ашиглалтад оруулахад захиалагчийн техник, технологийн хяналтын чиг үүргийг гэрээний дагуу үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх

- Баянхонгор аймгийн Авто зам, тээврийн хяналтын улсын байцаагчаас замын сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлсэн 254.2 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээнд хяналт тавьж ажиллаагүй;

- Баянхонгор аймгийн замын сангийн хөрөнгөөр Баянхонгор сумд эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн 514.4 сая төгрөгийн өртөг бүхий 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх болон ажлыг хүлээн авахдаа авто зам, тээврийн хяналтын улсын байцаагчийг ажиллуулаагүй байна.

Энэ нь Авто замын тухай 11 дүгээр зүйлийн 11.1.12<sup>17</sup>, 21 дүгээр зүйлийн 21.1,<sup>18</sup> 34 дүгээр зүйлийн 34.1<sup>19</sup>, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4.1.3<sup>20</sup>, 4.4.1.5<sup>21</sup>, 4.8.2<sup>22</sup> дахь заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт:** Холбогдох хууль, тогтоомжийн дагуу замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, хяналтыг хэрэгжүүлэн ашиглалтад авч байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад, албан шаардлагыг Баянхонгор сумын Засаг дарга нарт өгөхөөр шийдвэрлэв.

3.7. Баянхонгор сумын Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн “Баянхонгор сумын доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх” ажлыг аймгийн Замын сангийн хөрөнгөөс 100.0 сая, Баянхонгор сумын ОНХС-аас 48.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр ИТХ-ын тогтоол гарсан байхад гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан БХАХААГ/20250201041 дугаартай гэрээ байгуулсан байна.

Тус төсөл, арга хэмжээний санхүүжилтийг замын сангийн хөрөнгөөс 148.7 сая төгрөгийг олгохоор гэрээ байгуулсан, Баянхонгор сумын ОНХС-аас олгох санхүүжилтийг олгоогүй байгаа тул аудитын явцад гэрээний үнэ, төлбөр нөхцөлийг залруулж, гэрээг шинэчлэн байгуулсан болно.

---

<sup>17</sup> Авто зам, замын байгууламжийн техник технологийн хяналтыг захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлэх

<sup>18</sup> Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллага захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр хэрэгжүүлнэ”

<sup>19</sup> Авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналтыг авто замыг өмчлөгч, эзэмшигч, зам хариуцагч байгууллага, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга, холбогдох албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

<sup>20</sup> Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг: төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлийн санхүүжилтийн явц бүрд захиалагчийн техник, технологийн хяналтын тэмдэглэл, явцын тайлан, дүгнэлтийг тухай бүр цахим системд оруулах;

<sup>21</sup> захиалагчийн техник, технологийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэргэжлийн түвшинд, чанартай, үр ашигтай, ил тод, нээлттэй болон хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэх

<sup>22</sup> Захиалагч нь захиалагчийн техник, технологийн хяналт тавих этгээдтэй захиалагчийн хяналтын гэрээ заавал байгуулсан байх бөгөөд гэрээний хуулбарыг тухайн төслийн гүйцэтгэлийн баримт бичигт хавсарган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр ирүүлнэ

**Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОНХОБТ нь өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, албан шаардлагын хариуг заасан хугацаанд ирүүлээгүй байна.**

3.8. Орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, иргэдэд амьдрах таатай орчин бүрдүүлсэн байна.

3.9. Баянхонгор аймгийн ИТХ-ын тогтоолоор тайлант онд бий болсон 5,770.5 сая төгрөгийн 24 төсөл арга, хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд хөрөнгөөр, 505.4 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг урсгал зардлаар тусгаж, 2026 он гарсаар 38.9 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэжээ.

3.10. Тайлант хугацааны төсөл, арга хэмжээнээс хүлээн аваагүй 1, 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа 3 төсөл арга хэмжээ байна.

3.11. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж, 2025 онд хүлээн авсан 1,001.3 сая төгрөгийн гэрээний дүн бүхий 8 төсөл, арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгах шийдвэр эрх бүхий байгууллагаас гараагүйгээс хүлээгдэж байна.

Иймд төсвийн хөрөнгөөр бий болсон, хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр эзэмшигч тогтоох шийдвэр гаргуулж, нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн эсэхийг 2026 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар үзэхээр шийдвэрлэв.

#### **Аудитын илрүүлэлт:**

Замын сан болон Эрдэнэцогт сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 162.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий зам, даваа засах тусгай зориулалтын ковшийг 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдөр хүлээн авсан байхад тус техникт улсын бүртгэлийн гэрчилгээ олгогдоогүй, улсын дугаар аваагүй байна.

Энэ нь Авто тээврийн тухай хууль 17 дугаар зүйлийн 17.1<sup>23</sup> дэх заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт:** Тусгай зориулалтын ковшийн улсын дугаар, техникийн гэрчилгээг гаргуулж, зөрчлийг арилгах албан шаардлагыг Эрдэнэцогт сумын Засаг даргад өгөхөөр шийдвэрлэв.

3.12. Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан төсөл, арга хэмжээний үр дүнг тоо болон чанарын үзүүлэлтээр тодорхойлоогүй, тайлагнаагүй нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.2.11<sup>24</sup> дэх заалттай нийцэхгүй байгаа, аудитаар зорилтот үр дүнд хүрсэн талаарх дүн шинжилгээг хийх

<sup>23</sup> Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ

<sup>24</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: Төсвийн хөрөнгө оруулалтын тайлан, үр дүн, үр ашгийг тооцох, мэдээллийн сан бүрдүүлэх;

боломжгүй байгаа тул Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг гүйцэтгэлтэй нь харьцуулах дүгнэх боломжтой байна.

3.13. Өмнөх оны аудитаар нийт 7,118.9 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 42.4 сая төгрөгийн дүнтэй 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 7,076.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 7 албан шаардлага, зөрчлийг цаашид давтан гаргуулахгүй байх чиглэлээр 4 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлсэн байна.

Хүснэгт 6 . Өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт

Шийдвэрийн нэр	Зөрчлийн утга	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Шийдвэрийн хэрэгжилт	Аудитаар тооцсон хэрэгжилт /хувиар/
Төлбөрийн акт	Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлын хүрээнд дээврийн ажил хийж гүйцэтгэсэн гэж гүйцэтгэлийн 42.4 сая төгрөгөөр гаргасан боловч дээвэрт ажил хийгээгүй байна.	Аймгийн ЗДТГ	2025.08.07-нд төлбөрийн актыг төвлөрүүлсэн	100%
Зөвлөмж	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлага, нийгмийн ач холбогдлыг эрэмбэлэхгүй байна.	Аймгийн засаг дарга	Аймгийн Засаг даргын 2025.12.17-ны өдрийн 1а/1125 дугаар албан бичиг	50%
	Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн хууль болон бусад хууль тогтоомжоор заасан хугацаанд багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.			61.5%
	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж аймгийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээг тайлант хугацаанд нь багтаан бүрэн хэрэгжүүлээгүй байна.			80%
	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа барилга, байгууламжийн гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт, хүлээн авах улсын комисст мэргэжлийн шинжээчийг оруулаагүй байна.	Сумдын Засаг дарга нарт		70%
Албан шаардлага	Зураг төсөв, техникийн тодорхойлолт хийгдээгүй 3,961.9 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын жилийн хөгжлийн төлөвлөгөө болон 2024 оны хөрөнгө оруулалтын төсөвт оруулан баталсан байна.	Аймгийн Засаг дарга, Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн дарга	Аймгийн Засаг даргын 2026.05.08-ны өдрийн 1а/410 дугаар албан бичиг	50%
	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй 356.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээг баталсан байна.	Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн дарга		100%
	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Бууцагаан сумын хуучин сургуулийн барилгыг ашиглаагүй байна.	Аймгийн Засаг дарга, Боловсролын газар		Аймгийн Засаг даргын 2026.05.08-ны өдрийн 1а/410

Баян-өндөр сумын Эрүүл мэндийн төвийн засварын ажлын төсөвт гадна засал, бохир усны шаазан угаалтуур, шалны ажил, дээврийн ажлыг тус тус гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч Эрүүл мэндийн төвийн дарга төсөв зохиогчийн зөвшөөрөлгүй засварын ажлыг зөвшөөрөлгүй өөрчилсөн байна.	Аймгийн Засаг дарга, Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-ийн дарга	дугаар албан бичиг, Баян-Өндөр сумын Засаг даргын 2025.05.08-ны өдрийн Б/7 дугаар захирамж	100%
Баянбулаг сумын хуучин сургуулийн барилгын гадна фасадын ажлын төсөв зохиогч ажлын тоо хэмжээг дутуу тооцоноос шалтгаалж дотор заслын ажлыг нэмж гадна фасадын ажилд оруулсан.	ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргын 2025.11.28-ны өдрийн 773 дугаар албан бичиг	100%
Эрдэнэцогт сумын цагдаагийн байрны засварын ажлыг гүйцэтгэгч нь 15.0 сая төгрөгийн гэрээний дагуу хийгдсэн барилгын засварын ажлын хүрээнд 170 м2 талбай бүхий дээврийг будах, гадна эмульс хийх, дотор лампиран тааз, гэрэлтүүлэг лого, Гадна бүргэд хаалга 2 ширхэг, дотор модон хаалга 2 ширхэг дотор обой үүдний тамбар гэх мэт бусад засвар үйлчилгээний ажлыг чанаргүй хийж гүйцэтгэсэн байна.	ГХБХБГ	ОНӨГ-ын даргын 2025.11.28-ны өдрийн 773 дугаар албан бичиг	100%
Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн 2,402.3 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг 2024 оны эцэст болон 2025 он гарч хүлээн авсан бөгөөд хөрөнгөд эзэмшигч тогтоох эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүйгээс шалтгаалж хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна.	Аймгийн Орон нутгийн өмчийн газар	ОНӨГ-ын даргын 2025.12.09-ний өдрийн 342 тоот албан бичиг	100%

Эх сурвалж: Аудитын шийдвэрийн биелэлт ирүүлсэн албан бичгүүд

3.14. Баянхонгор аймгийн ГХБХБГ, ОНӨГ нь албан шаардлагын хариу хугацаанд нь нотлох баримтын хамт ирүүлсэн байна.

3.15. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг заасан хугацаанд гаргаж ирүүлээгүй, зарим албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлээгүйгээс аудитаар зөрчлүүд давтагдан гарч байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3<sup>25</sup> гэснийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэлт:** Өмнөх оны аудитаар өгсөн дутуу хэрэгжсэн албан шаардлагыг бүрэн биелүүлж, зөрчлийг таслан зогсоож, хэрэгжилтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор албан бичгээр хариу ирүүлэхийг аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ-т зөвлөв.

Аудитаар нийт 5,089.9 сая төгрөгийн 9 зөрчил илрүүлж, 1,975.5 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг арилгуулах 6 албан шаардлага өгч, 3,114.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар 4 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

---оОо---

<sup>25</sup> Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэн.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.
1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар төсөв хэлэлцэх явцад нэмж баталдаг, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний үр дүнг тооцож төлөвлөдөггүй зөрчил жил бүр давтагдаж байна.
2. Зураг төсөв, техникийн тодорхойлолтыг бүрэн боловсруулаагүй байхад төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан нь худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулах боломжийг хязгаарлаж байна.
3. Орон нутгийн төсвийн болон замын сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, иргэдэд амьдрах таатай орчин бүрдүүлсэн байна.

## **ЗӨВЛӨМЖ**

### **НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ИТХ-Д ТОЛИЛУУЛАХ НЬ**

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг батлахдаа Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасан төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсөв хэлэлцэх явцад ИТХ-аар нэмж батлах зөрчил давтагдсаар байна.
2. Замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Баянхонгор сумын 3 дугаар сургуулийн баруун урд уулзвараас нэгдсэн эмнэлгийн уулзвар хүртэлх 1.3 км авто зам тавих ажлын 2026 онд санхүүжүүлэх дүнг 1,002.8 сая төгрөгийг баталсан нь гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дүнгээс 4.2 сая төгрөгөөр илүү байна.

**Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:**

### **НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Э.ЭНХБАТ ТАНАА**

1. Төсөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөв, магадлалын дүгнэлттэй, техникийн тодорхойлолттой төсөл, арга хэмжээг төлөвлөж, үр ашгийг тооцсон нэгдсэн судалгаа боловсруулж, гарах үр дүнг тооцож байх.
2. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний зураг, төсөв зохиолгох зөвлөх үйлчилгээг шууд гэрээгээр гүйцэтгүүлдэг байдлыг таслан зогсоож гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулж байх
3. Холбогдох хууль, тогтоомжийн дагуу замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байх

### **ХОЁР. АЙМГИЙН ЗДТГ-ЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА ТАНАА**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалтын дагуу 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулсан худалдан авах ажиллгааны төсвийн хэмнэлт, тус хугацаанд багтаан зохион байгуулаагүй төсөл арга хэмжээний санхүүжилтийг хуульд зааснаар хэмнэлтэд тооцож тус тус орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэх.